



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2022 оны 08 сарын 02 өдөр

Дугаар А/388

Улаанбаатар хот

Магадлан итгэмжлэл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2022 оны 8 дугаар сарын 01-ний өдрийн 14 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын нэрсийг хавсралтаар баталж, батламжийг олгосугай.

2. Магадлан итгэмжлэлийн хугацаа тасарч сунгагдаж буй эрүүл мэндийн байгууллагуудын магадлан итгэмжлэл эхлэх хугацааг 2022 оны 8 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн тооцсугай.

3. Магадлан итгэмжлэлийн хугацаанд тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулж, шинжээчдийн багийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

4. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2022 оны 8 дугаар сарын 01-ний өдрийн 14 дүгээр хурлын шийдвэрийг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрийн захиргаа удирдлагын газар /П.Эрхэмбаяр/-т, Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/ -д тус тус үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/-т даалгасугай.

САЙД



С.ЭНХБОЛД

141221874

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 08
дугаар сарын 02-ны өдрийн А/388
дугаар тушаалын хавсралт

МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭРС

№	Эрүүл мэндийн байгууллагын нэрс	Батламжийн дугаар	Магадлан итгэмжлэгдсэн хугацаа	Магадлан итгэмжлэл эхлэх огноо	Магадлан итгэмжлэл дуусах огноо
1.	Архангай аймаг, Бор талын хишиг ХХК-ийн Сувд сувилал	262/2022	4 жил	2022.08.01	2026.08.01
2.	Архангай аймаг, Тунгалаг тамир эмнэлэг	263/2022	3 жил	2022.08.01	2025.08.01
3.	Архангай аймаг, Зүүхэн ХХК-ийн эмнэлэг	264/2022	4 жил	2022.08.01	2026.08.01
4.	Архангай аймаг, Дөлгөөн арц ХХК-ийн эмнэлэг	265/2022	2 жил	2022.08.01	2024.08.01
5.	Говь-Алтай аймаг, Аймгийн нэгдсэн эмнэлэг	266/2022	4 жил	2022.08.01	2026.08.01
6.	Завхан аймаг, Алдархаан сумын Отгонтэнгэр рашаан сувилал	267/2022	2 жил	2022.08.15	2024.08.15

оо0оо